# ЖИЖИГ УЛСЫН ТУСГААР ТОГТНОЛ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ УЛСТӨР, ДИПЛОМАТЫН АРГААР БЭХЖҮҮЛЭХ АРГА ЗАМ. МОНГОЛЫН ЖИШИГ

**С.Галсанжамц**

*"Цэнхэр Сүлд " нийгэмлэгийн Удирдах зөвлөлийн гишүүн*

## Нэг. Их гүрний бөөрөнд орших жижиг улсын аюулгүй байдал, улс түмний хувь заяа

Олон улсын харилцааны түүхэнд аливаа жижиг улсын тусгаар тогтнол, аюулгүй байдал тухайн бүс нутгийн геополитикийн нөхцөл, их гүрнүүдийн ашиг сонирхолоос үлэмж хамаарч ирсэн байдаг. Бага буурай орны газар зүйн байрлал хийгээд түүхэн хөгжлийн явцад хувьсан өөрчлөгдөх түүний стратегийн ач холбогдол, эрт орой илрэх байгалийн баялагийн нөөц зэрэг хүчин зүйл тухайн улсын хувь заянд ихээхэн үүрэгтэй. Үүнээс гадна жижиг орны зүгээс том ах нартай харилцах харилцаандаа тэдний ашиг сонирхолын эсрэг алхам хийж бодлогын алдаа гаргах, дотооддоо хагаран тэмцэлдэж, улстөрийн тогворгүй байдал үүсгэх зэрэг нь их гүрний зүгээс тухайн орны дотоод хэрэгт хүчээр оролцож, эрхшээлдээ оруулах шалтгаан болдог.

Өнөөдөр ч энэ байдал өөрчлөгдөөгүй. Бидний мэдэх Европын түүхээс харахад төв болон зүүн Европын жижиг улсууд нэг талаас Герман/Прус, Австри-Унгар, нөгөө талаас Орос/Зөвлөлтийн сөргөлдөөн, хуйвалдааны золиос болж байсан жишээг олныг дурдаж болно. Тэдгээрээс зөвхөн Польшийн шижээг авч үзэхэд тус улсыг 1772 оноос 1939 оныг хүртэл хөрш зэргэлдээ хүчирхэг орнууд өөр хоорондоо тохирон таван удаа хуваан ээлж байжээ. Хамгийн сүүлд 1939 оны Молотов-Рибентропын гэрээгээр ЗХУ, Гитлерийн Германтай үгсэн хүчээр булаан авсан Полыпийн зүүн хэсэг өнөөдрийн Украин, Белорусын газар нутгийг үлэмж хэсгийг бүрдүүлж байна. 1939 оны 9 дүгээр сарын 28-нд Полыиийг “ялсны” баярыг тохиолдуулан Брест хотноо фашист Герман, улаан Оросын цэргийн хамтарсан парад хийж байсныг Зөвлөлт-Оросын түүхчид тэр болгон дурдаад байдаггүй.

Их гүрнүүдийн ашиг сонирхолын улмаас эзлэгдэж, хуваагдаж, таслагдсан улс үндэстнүүдийн хувь тавилан үнэнхүү эмгэнэлтэй. Тэд ихэвчлэн улс төр, шашин, эдийн засаг, соёлын хавчилага, түрэмгийлэлд өртөн тусгаар тогтнол, үндэсний шинж тэмдэг, хэл соёлоо алдаж, өвөг дээдсээс нь заясан төрөлх газар шороон дээрээ амьдарч байгаа хэрнээ харъяалагдаж буй гүрний хүн амын дотор доод зэрэглэлийн хүмүүс болж хувирдаг.

Дэлхийн II дайны төгсгөлд АНУ, ЗХУ-ын тохиролцоогоор хуваагдсан Солонгос үндэстэн эдүгээ нэгдлээ гэхэд нэгэн дээвэрт багтаж чадахгүй хэмжээнд хүртлээ өөр хоорондоо ялгаатай болж, нэгдэл нь тэдэнд эерэгээсээ сөрөг үр дагавар илүү авчрах магадлалтайгаас гадна солонгосын хойгийн хямрал нь зөвхөн бүс нутгийн бус олон улсын аюулгүй байдлын зангилаа асуудлын нэг болоод байна.

Төвд, уйгур үндэстнүүдийн хувь заяа, хэдхэн жилийн өмнө Гүржид болсон явдал (газар нутаг нь үндсэндээ гурав хуваагдсан), Крымын хойг, Украины зүүн мужуудын сөргөлдөөний эх үүсвэр бүгд л их гүрний ашиг сонирхол хөндөгдсөнөөс үүдэлтэй.

**Хоёр. Монголын газар нутаг, монгол үндэсний хуваагдсан түүх**

Монгол хэмээх үндэстэн буй болсон цагаас эхлэн Төв Азийн өргөн уудам нутагт мал аж ахуй эрхэлэн нүүдэллэн амьдарч ирсэн түүхтэй. Манай эриний VII-VIII зуунд нүүдэллэн одсон түрэгүүдээс өөр үндэстэн энэ газар нутагт амьдарч байгаагүй. Монголын их гүрэн задран унаснаас хойш ч уугуул монголчууд Байгал нуураас Хятадын цагаан хэрэм, Их Хянганы нуруунаас Балхаш нуурын хооронд нүүдэллэн амьдарч байсан.

Түүхэн хөгжлийн явцад хоёр их соёл иргэншил, хоёр том үндэстний хил хязгаарыг зааглан амьдарч ирсэн монголчууд сэргэн мандаж, хүчирхэг байх үедээ хөрш улсуудаа байлдан дагуулж, эрхшээлдээ байлгаж, засан тохинуулж байсан хэдий ч хувь заяаны эрхээр эргээд тэднээс хамааралтай болж, газар нутаг, элгэн саднаа хэд тасдуулан гашуун зовлон туулсан хэдий ч нэг хэсэг нь гал голомтоо сахин аж төрсөөр хэдэн зууныг элээж байна.

Ази-Европыг дамнасан Монголын их гүрэн задарснаас хойш Монголчууд дээр дурдсан хангалттай өргөн уудам нутагтай үлдсэн боловч бага хаадын өөр хоорондын тэмцэл, баруун зүүн, шар улаанаара талцан сөргөлдсөний харгайгаар дахин хэд хуваагдан илүү хүчирхэг нэжгээдийн идэш болсныг бид мэднэ.

Хоёр толгойт махчин шувуун сүлдтэй хаант Орос нэгэнтээ Сибирийн өргөн уудам нутгийг хүчээр булаан эзлэхдээ өмнөд Сибирь, Байгал нуурын сав газарт амьдарч ирсэн монгол үндэстнийг эрхшээлдээ оруулж, элгэн саднаас нь тусгаарласан. Үүнийгээ 1727 онд Манж чин улстай байгуулсан Буурын хэлэлцээрээр баталгаажуулан хил тогтоосон нь өнөөгийн Монгол Улсын умард хил болжээ. Хожим Манжид дагаар орохоос татгалзсан буриад нар өөрсдөө оросыг бараадан нүүдэллэсэн байдаг.

XVII зуунд хүчирхэгжсэн Манж чин улсын захиргаанд Өвөр монголчууд 1636 онд орсноор монголын газар нутгийн хоёр дахь хуваалт болж. 1691 онд халх монголчууд дагаар орох хүртэл 50 гаруй жил тусгаарлагдмал байсан хилийн зааг өнөөгийн Монголын өмнөд хил болон үлджээ.

Монголын үе үеийн удирдлага, тэргүүнтэн нар хуваагдсан эх нутаг, элгэн саднаа нэгтгэхийг эрмэлзэн цагийн өөрчлөлтийг далимдуулан олон удаагийн оролдлого хийсэн боловч тэр нь хөрш их гүрнүүдийн ашиг сонирхолд харшилсны улмаас биелэх тавилангүй байсан юм. Энэ саад зөвхөн хөрш орнуудын ашиг сонирхолоор хязгаарлагдаагүй. 1912 онд байгуулагдсан хаант Орос, Японы нууц хэлэлцээрээр Ар Монголыг Оросын, Өвөр Монголыг Японы ашиг сонирхолын бүсэд хуваахаар тохирсон нь монголын газар нутгийн хуваагдлыг баталгаажуулж, эргэн нэгдэх боломжийг үгүйсгэхэд ихээхэн нөлөөлсөн байдаг.

**Гурав. XX зууны Монголын тусгаар тогтнолын түүхийн тухай эргэцүүлэл**

Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдал нь хөрш орнуудын өөр хоорондын харилцаа, тэдгээрийн ашиг сонирхолын өөрчлөлт хийгээд тэдгээрийн зүгээс Монголын талаар явуулж ирсэн бодлогоос үлэмж хамаарч ирсэн түүхтэй.

Монголын байгаль, цаг уурын нөхцөл нь суурин соёл иргэншилтэй хөрш орны иргэдийн хувьд олноор хүч түрэн ирж амьдрах сонирхолыг татах таатай оршин биш байсан нь манай орны тусгаар тогтнолыг хамгаалах бурханаас заясан **байгалийн** хүчин зүйлийн нэг байсан байж болох талтай. Гэвч газар зүйн байрлалын хувьд геостратегийн чухал ач холбогдолтой, байгалийн нөөц баялагтай, хэрэглээний түүхий эдийн арвин эх үүсвэртэй, ядуу буурай орныг эрхшээлдээ байлгах сонирхол Бээжин, Москвагийн аль алинд нь байснаас хэн хэндээ буулт хийгээгүй, Монголоос болж хоорондоо муудалцахаас зайлсхийж, үгсэн хуйвалдаагүй **гадаад улс төрийн** хүчин зүйл манай орны тусгаар тогтнолыг хадгалахад гол нөлөөтэй байсан нь түүхэн үнэн билээ.

Үүнээс гадна XVIII-XIX зуунд Орос, Хятадын хүчний харьцаа харьцангүй тэнцвэртэй байсан нь аль нэг тал хүч хэрэглэн монголын асуудлыг өөртөө ашигтай шийдэх боломжийг тэр болгон олгоогүй. Тэр болгон гэж хэлсний учир хүчний харьцаа алдагдах хэд хэдэн тохиолдол гарч, тухай бүрд Монголын тусгаар тогтнол жингийн тавганд дэнжигнэж, зарим

үед алдагдаж байсан түүхтэй. Тухайлбал Октябрийн хувьсгалын дараа Орос орон иргэний дайны галд дарагдаж, хүчин мөхөсдөх үед Хятадын цэрэг Монголд орж, автономит эрхийг устган ноёрхлоо тогтоосон байдаг.

Хэдийгээр тэр үеийн Богд хаант засгийн газрын зарим эрхтэнүүд улаантны аюулаас хамгаалах зорилгоор хятадын цэргийг Монголд оруулах "хүсэлт" тавьсан баримт байдаг ч Оросын хүчин мөхөдсөн таатай боломжийг ашиглан ар Монголыг эрхшээлдээ авах Бээжингийн санаархал анх удаа биелэлээ олсон нь энэ байлаа.

Монголын асуудлыг хөндсөн Орос, Хятадын гэрээ хэлэлцээрүүдэд Монголд цэрэг оруулахыг хориглосон заалт заавал ордог байсан юм. Нөгөө талаас манай хоёр хөршийн хэн нь түрүүлж Монголд цэргээ байрлуулж, эрхшээлээ тогтоосон нь цэрэг, улс төрийн давуу байдал эдлэх геостратегийн хожоотой учир тийм боломж, шалтаг олдох бүрийг алддаггүй байсан гэж хэлж болно.

1921 онд улаан армийн ангиуд Монголд орж ирэхдээ зөвхөн цагаантны цэргийн хүчийг дарах зорилготой бөгөөд уг үүргээ гүйцэтгэсний дараа Монголоос цэргээ гаргана гэсэн амлалтыг Бээжинд гаргаж өгсөн байдаг. Эл амлалтаа биелүүлсэн хэдий ч дотоод, гадаадын тогтвортой байдлыг хангах хүртэл улаан армийн цэргийн ангиудыг үлдээх хүсэлтийг Монголын хувьсгалт засгийн газраас "гаргуулан" 1925 оныг хүртэл цэргээ байрлуулж байлаа. Монголоос цэргээ гаргахыг Бээжингээс тууштай шаардаж байсан нь энэ алхам хийхээс өөр аргагүйд хүргэсэн юм билээ.

1930-аад оны дундуур Монголын зүүн хязгаарт тогтворгүй байдал үүдсэн үед БНМАУ, ЗСБНХУ-ын хооронд Найрамдал, хамтын ажиллагаа, харилцан туслалцах тухай Протокол байгуулагдаж, Монголын тусгаар тогтнолыг гадны түрэмгийллээс хамгаалах зорилгоор Зөвлөлтийн цэрэг хоёрдахь удаагаа монголын нутагт орж ирсэн. Энэ үед Хятад орон Японы түрэмгийлэл, иргэний дайнд нэрвэгдэж, Монголын анхаарах сэхээгүй болсон байлаа.

Дэлхийн II дайны төгсгөлд Японы цэргийн хүчийг Алс Дорнодод бутцохих чөлөөлөх дайнд оролцохоор Германыг бутниргэсэн Зөвлөлтийн хүчирхэг улаан цэрэг Монголд гуравдах удаа орж ирэхдээ Хятадаас эмээх шаардлага мэдээж байгаагүй.

1960-аад оны эхээр Москва, Бээжингийн хооронд үзэл суртлын зөрөлдөөн гарч, тэр нь улмаар улс төр, цэргийн сөргөлдөөн болсон үед Зөвлөлтийн бодлогыг дагаагүй Хятадын удирдлагад шахалт үзүүлэхээр Зөвлөлтийн зэвсэгт хүчний томоохон бүлэглэл орж ирснийг бид мэднэ. Газар

зүйн байрлалын хувьд Бээжинд ойрхон, давшилтын ажиллагаанд учрах байгалийн саад үгүй Монголын газар нутгийн стратегийн давуу талыг Москва цэрэг. улс төрийн зорилгоо сүүлийн удаа ашигласан нь энэ байлаа.

Монгол улс XX зууны эхээр тусгаар тогтнолоо сэргээн тогтоосны дараа учирч болох заналхийллийг өмнө зүгээс ирэхээр төсөөлж байсан учир ЗХУ-тай цэрэг, улс төрийн холбоотны харилцаа тогтоон аюулгүй байдлаа хамгаалуулж ирсэн. Өөр сонголт үнэндээ байгаагүй. Гэхдээ Зөвлөлтийн цэрэг байралснаар манай орны аюулгүй байдал үнэхээр баталгаажсан байсан уу гэсэн асуултад өнөөдрийн байр суурьнаас хариулахад эргэлзээ төрүүлэх зарим хүчин зүйл байдаг.

Монголын нутагт байрлаж байсан Зөвлөлтийн цэргийн зэвсэглэлд тактикийн цөмийн зэвсэг байсан тухай яриа таамаглал үндэслэлтэй болох нь нотлогдсон. Аливаа томоохон цэргийн бүлэглэл түүний дотор цөмийн зэвсгийн нөөц сөрөг талын хариу дайралт эсвэл өрссөн цохилтын бай болдог нь дайны стратегийн батлагаажсан хууль. Зөвлөлт, Хятадын сөргөлдөөний оргил үе болох 1979 оны өвөл Камбожид Вьетнамын цэрэг орсонтой холбоотой ХАЧА-ийн танкийн ангиуд Вьетнамд халдмагц Сибирт өргөн хэмжээний дайчилгаа явагдаж, Өвөр Байгаль, Сибирийн цэргийн тойргийн анги нэгтгэлүүд БНМАУ-д ирж, Монголын цэргийн ангиудтай хамтран Монгол, Хятадын хилийн дагуу томоохон хээрийн сургууль хийсэн. Зөвлөлт, Монголын цэргийн ангиуд энэ хээрийн сургуульд байлдааны бүрэн зэвсэглэл, галт хэрэглэлтэй оролцсон бөгөөд хятадын цэрэг Вьетнамаас гараагүй бол үйл явдлын өрнөл хэрхэн үргэлжлэх байсныг таахад бэрхшээлтэй.

Ийнхүү бид тухайн үед гарч болох үйл явдлын учир холбогдол, сөрөг үр дагаварыг төдийлөн анзаараагүй өнгөрсөн боловч Монголын газар нутаг Зөвлөлт, Хятадын цэргийн сөргөлдөөний талбар болох, болзошгүй халуун цөмийн дайны хөлд нэрвэгдэх эрсдэл тун ойрхон байсан юм. Үүнээс гадна хүйтэн дайны үеийн ЗСБНХУ, АНУ-ын сөргөлдөөний жилүүдэд бие биеийн эсрэг онилсон стратегийн цөмийн пуужингуудын байнуудын жагсаалтад Монгол дахь Зөвлөлтийн цэргийн бүлэглэл орж байсан гэдэг мэдээ ч байдаг.

Иймээс хүйтэн дайн үеэ өнгөрөөж, Зөвлөлтийн цэрэг Монголоос гарч, олон улсын харилцаанд эрүүл уур амьсгал давамгайлах болсноор манай орны гадаад аюулгүй байдал илүү баталгаажсан гэж хэлэх бүрэн үндэс бий.

**Дөрөв. Шинэ нөхцөлд аюулгүй байдлаа хангах арга замыг сонгосон нь**

Хүйтэн дайн дуусгавар болж, олон улсын харилцаанд нааштай өөрчлөлт давамгайлах болсон үед том ахын нөлөөнөөс ангижирч, ардчилсан тогтолцоонд шилжсэн шинэ Монгол Улс анх удаагаа бие даасан олон тулгуурт гадаад бодлого явуулах боломжтой болсны дараа улс орны тусгаар тогтнол, аюулгүй байдлаа өөрийн хүчээр хангах амаргүй сорилттой тулгарсан юм.

Щвейцарь лугаа төвийг сахиж, бие даасан хатуу бодлого баримтлан хэрэгжүүлэхэд шаардлагатай улс төрийн даацтай жин, эдийн засгийн чадамж дутуу учир боломжгүй, холбоотны харилцаагаа үргэлжлүүлэн хөрш гүрний ивээлд аюулгүй байдлаа хангах нь өнгөрүүлсэн түүхийн сөрөг үр дагаварыг давтах магадлалтайг харгалзан бие даасан, нээлттэй гадаад бодлого баримтлан, олон улсын хамтын нийгэмлэгтэй эрх тэгш харилцаа хөгжүүлэн тусгаар тогтнол, гадаад аюулгүй байдлаа улс төр, дипломатын аргаар баталгаажуулах замыг сонгосон нь ухаалаг алхам болсон билээ.

Улс төр, нийгмийн тогтвотой байдал, эдийн засгийн бие даасан хөгжил, байгаль экологийн тэнцвэртэй байдлыг хангах, монгол соёл иргэншил, өв уламжлалаа сэргээн хөгжүүлэх, эх оронч үндэсний үзлийг хэвшүүлэх, ардчилсан нийгмийн тогтолцоо, зах зээлийн эдийн засгийн харилцааг туйлбартай бэхжүүлэх, хууль дээдэлсэн шудрага ёс тогтоох нь улс орны үндэсний аюулгүй байдлыг хангах дотоодын тулгуур үндэс болох байлаа.

Улс төр, дипломатын аргаар аюулгүй байдлаа бэхжүүлэх бодлогын хүрээнд хэрэгжүүлж ирсэн хэд хэдэн нааштай алхамууд үр дүнтэй үргэлжилж байна. Бие даасан нээлттэй гадаад бодлого баримтлан олон улсын харилцаанд нөлөө бүхий өндөр хөгжилтэй орнуудыг хамруулсан гуравдах хөршийн бодлогыг хэрэгжүүлсэн нь тэнгэрээс заясан хоёрхон хөршийн ашиг сонирхолыг тэнцвэржүүлэх гуравдах тогтвортой тулгуур болж чадсан гэж хэлэх бүрэн үндэслэлтэй. Гуравдах хөршийн орнуудтай тогтоосон харилцаанд ихэвчлэн цэвэр улс төрийн, зарим орнуудтай батлан хамгаалах салбарын хамтын ажилллагаа давамгайлж байгаа нь газарзүйн хөрш орнуудын хардлагыг төрүүлэх шалтгаан мөн хэдий ч энэ харилцааг хөршүүдийнхээ ашиг сонирхолыг хөндөх хэмжээнд хүргэлгүй, тодорхой хязгаарын хүрээний дотор байлгах нь туйлын чухал юм.

Монголын Зэвсэгт хүчний командлалаас санаачилж, зоригтой хэрэгжүүлсэн энхийг сахиулах болон терроризмтай тэмцэх олон улсын ажиллагаанд үндэсний цэргийн багуудыг амжилттай оролцуулж байгаа нь тайван цагт зэвсэгт хүчнийг ашиглах төрийн цэргийн бодлогын үндэсийг

хэрэгжүүлж буй амжилттай жишээ төдийгүй Монгол Улсын нэр хүндийг олон улсын тавцанд өргөсөн чухал алхам болж байна. Энхийг сахиулах олон улсын цэргийн ажиллагаан дахь монголын цэргийн идэвхитэй, үр дүнтэй оролцоо Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний бэлэн байдлыг хангах, үүрэг гүйцэтгэх чадварыг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтойгоос гадна ажиллагааны явцад хамтран ажилладаг дэлхийн бодлогод нөлөө бүхий орнуудтай батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа хөгжүүлэн өргөжүүлэхэд түлхэц өгч байгаагаараа улс төрийн томоохон ач холбогдолтой.

**Тав. Нутаг дэвсгэрээ цөмийн зэвсэггүй бүсээр тунхагласан нь аюулгүй байдлаа улс төр-дипломатын аргаар бэхжүүлэхэд чиглэсэн далайцтай алхам болов**

Өдгөөгөөс 25 жилийн тэртээ Монгол Улсын анхны Ерөнхийлөгч Пунсалмаагийн Очирбат НҮБ-ын Ерөнхий Ассамблейн хүндэт индэрээс Монгол Улс өөрийн нутаг дэвсгэрээ цөмийн зэвсэггүй бүс (ЦЗБ) хэмээн зарлаж байгааг дэлхий нийтэд тунхагласан билээ.

Дэлхийн II дайны төгсгөлд АНУ цэрэг дайныхаас илүү улс төрийн зорилгоор Японы хотуудыг бөмбөгдөж цөмийн зэвсгийн аюулт хор хөнөөлийг дэлхийд мэдүүлснээс хойш цөмийн зэвсгээр хөөцөлдөх, цөмийн зэвсгийг устгах гэсэн хөдөлгөөн зэрэг өрнөж, өдгөө 70 гаруй жилийг элээсэн ч хэн хэнийгээ дийлж чадаагүй хэвээр байна. Сөрөг хоёр системийн өрсөлдөөнөөс улбаатай цөмийн хэнээрхэл хүн төрлхөтөнд бодит занал учруулж эхэлснийг мэдэрсэн улс орнууд энэ аюулыг зайлуулах зорилгоор цөмийн зэвсэггүй бүсүүдийг анх санаачилсан түүхтэй. 1962 оны Карибын хямрал дэлхий нийтийг халуун цөмийн дайны ирмэгт аваачиж, түүний хор хохиролын эн тэргүүнд амсах байсан тухайн бүс нутгийн орнууд нэгдэж Латин америкийн ЦЗБ байгуулсан нь энэ хөдөлгөөний эхлэл болсон юм. Улмаар Өмнөд Номхон далайн, Зүүн өмнөд Азийн, Африк тивийн, Төв Азийн ЦЗБ-үүд байгуулагдаж, эдгээр бүсүүдэд хамрагдах улс орнууд цөмийн зэвсэг боловсруулахгүй, туршихгүй, эзэмшихгүй, байрлуулахгүй үүрэг хүлээж гэрээнд гарын үсэг зурсан байдаг. Мөн эдгээр гэрээний нэмэлт протоколуудад цөмийн зэвсэгтэй орнууд нэгдэж, дээрх бүсүүдийн цөмийн зэвсэггүй статусыг хүлээн зөвшөөрч аюулгүйн баталгаа олгосноор бүсүүдийн цөмийн зэвсгээс ангид статус нь бүрэн утгаараа хэрэгждэг.

Монгол Улс цөмийн зэвсэггүй статус олж авах санаачлага гаргасан нь мөн л өөрийн учир шалтгаантай. Зөвлөлт-Хятадын цэрэг улстөрийн сөргөлдөөний оргил болсон 1979 оны хэрэг явдал, тухайлбал Хятад-

Вьетнамын асуудлын улмаас Зөвлөлт, Монголын цэргийн нэгтгэл ангиуд Хятадын хилд цөмрөхөд бэлэн байсан нь Карибын хямралын Ази дахь хувилбар болоход тун дөхөж, үйл явдлын өрнөл өөр хувилбараар үргэлжилсэн бол гарч болох байсан ноцтой үр дагаварыг төсөөлж чадсан манай дипломат ажилтнууд ЦЗБ-ийн асуудлыг үндэслэлтэй судлан боловсруулж, төрийн бодлогын хэмжээнд дэвшүүлснээр цөмийн зэвсэгтэй хоёр их гүрний дунд орших жижиг орны аюулгүй байдлыг олон улсын хэмжээнд эрх зүйн үндэслэлтэй баталгаажуулах боломж, гарцыг нээж чадсан юм.

Хэдийгээр Монголын санаачлага дэлхийн хамтын нийгэмлэг, түүний дотор цөмийн зэвсэг эзэмшигч их гүрнүүд болон олон улсын нэр төртэй байгууллагуудын өргөн дэмжлэгийг хүлээж, энх тайвныг бэхжүүлэх, цөмийн дайны аюулаас сэргийлэх, хөнөөлт зэвсгийг устгах бүх нийтийн үйл хэрэгт жинтэй хувь нэмэр оруулсан өндөр үнэлгээ авсан боловч Монгол Улсын цөмийн зэвсэггүй статус нь олон улсын хэмжээнд хууль эрхийн үндэстэй баталгаажаагүй, зөвхөн дэмжлэг хүлээсэн статусын хэлбэртэй байсан юм. Энэ байдал манай орны өөрийн онцлогтой холбоотой бөгөөд цөмийн зэвсэггүй бусад бүсүүдтэй харьцуулбал нь хэд хэдэн онцлог ялгаатай. Юуны өмнө, дээр дурдсанчлан Монгол Улсын бүс нь нэг улсын гэдгээрээ онцлог. Өөрөөр хэлбэл, хэд хэдэн улс цөмийн зэвсэггүй бүсэд нэгдэн, өөр хоорондоо гэрээ, протокол байгуулдаг бол нэг улсын цөмийн зэвсэггүй бүсэд тийм боломж байхгүй. Хоёрдугаарт, Монгол бол цөмийн зэвсэг бүхий хоёрхон улстай хиллэдэг, далайд гарцгүй улс. Тэгвэл цөмийн зэвсэггүй бусад бүсийн улсууд цөмийн зэвсэггүй орчинд оршдог. Өөрөөр хэлбэл, тийм улсууд цөмийн зэвсэгтэй улстай хиллэдэггүй. Монгол Улсын оршин буй бүс нутаг нь магадгүй, цөмийн зэвсгийн нягтралаараа дэлхийн хамгийн халуун цэг ч байж болох юм. Орос, Хятадын аль аль нь Монголын хилийн ойролцоох өөрийн газар нутагтаа ихээхэн хэмжээний цөмийн зэвсэг байрлуулах боломж, чадавхитай. Түүнээс гадна, монголын хилийн ойролцоо агаар мандал болон газар дор хийгдэж ирсэн цөмийн туршилтууд (Хятадын Лоб нуур, Казахстаны Семипалатинск дахь Оросын туршилтын талбай) манай хүн ам, байгаль орчинд хэрхэн нөлөөөлсөн хийгээд эдгээр туршилтуудын үр дагавар болон хожмын нөлөө нь одоогоор тодорхойгүй байна. Гуравдугаарт, Монгол Улсын хувьд шууд хиллэдэг, цөмийн зэвсэггүй өөр хөрш үгүй тул цөмийн зэвсэггүй бүс байгуулах асуудлаар хэлэлцэн зөвлөлдөх хамтрагч байхгүй юм.

Өнгөрсөн 25 жилийн хугацаанд Монгол Улс өөрийн энэ өвөрмөц статусаа олон улсын чанартай баримт бичгээр баталгаажуулах, цөмийн

зэвсэгтэй гүрнүүдээр албан ёсоор хүлээн зөвшөөрүүлэх, аюулгүй байдлын баталгаа гаргуулах чиглэлээр уйгагүй хөөцөлдөн, чармайлт гаргаж ирсний хүчинд чамалхааргүй амжилтанд хүрээд байна. Энэ зам шулуун дардан байгаагүй, гадаадын улс орнууд, олон улсын байгууллагуудтай олон удаагийн яриа хэлэлцээ өрнүүлж, зорилго, байр сууриа зөв ойлгуулах, дэмжлэг авахад учирч байсан саад бэрхшээлүүдийг тэвчээр, чармайлт гарган даван туулахын зэрэгцээ дотоодоо ч гэсэн үл ойлголцох тохиолдол нэг бус удаа гарч байсныг дурдахад юу нь илүүц.

Угаасаа ЦЗБ нь дэлхийн бодлогод нөлөө бүхий гүрнүүдийн стратегийн ашиг сонирхолыг хязгаарлаж байдгийн учир тэдний зүгээс хэзээ ч таатай хандаж байгаагүй. Монголын хувьд нэг улсын цөмийн зэвсэггүй статус олж авахаар чармайж байсан бусад улсуудаас урьтан санаачлага гарган түүнийгээ хэрэгжүүлж чадсан нь манай орны идэвхитэй дипломат бодлогын амжилт гарцаагүй мөн. Их гүрнүүдээс өнөөг хүртэл Монголын статуст эрх зүйн үндэстэй баталгаа гаргахаас цааргалж байгаа гол шалтгаан нь Монголын жишээн дээр бусад улсууд адилхан баталгаа гаргуулахыг эрмэлзэх “эвгүй жишиг“ тогтохоос эмээж байгаад оршино. Гэхдээ чамлахаас чанга атга гэдгийн адил анхалж Монголын санаачлагыг дэмжих хэлбэрээр тус тусдаа мэдэгдэл гаргаж байсан их гүрнүүд аажмаар хамтарсан мэдэгдэл гаргаж, хоёр талын гэрээ хэлэлцээрүүдэд статустай холбоотой тусгай заалт оруулж, НҮБ-ын ЕА-н удаа дараагийн тогтоолуудыг дэмжиж ирсэн бөгөөд одоогийн байдлаар цөмийн зэвсэгтэй таван гүрэн Монгол Улсын цөмийн зэвсэггүй статусыг хүндэтгэж, түүнийг зөрчихөд дөхөм үзүүлэх аливаа үйлдлийн хийхгүй гэсэн албан ёсны амлалт бүхий хамтарсан тунхаглал гаргаад байна. Дахин онцолж хэлэхэд өнөөгийн хүрсэн түвшин асар их хүчин чармайлт, олон тооны яриа хэлэлцээ, тууштай чанар, дипломат урлагийн үр дүнд буй болсон бөгөөд цаашид алхам алхамаар урагшлуулах замын суурь болох юм.

Монгол Улсын цөмийн зэвсэггүй статусыг олон улсын хэмжээнд эрх зүйн үндэстэй баталгаажуулахад дэм үзүүлэх зорилгоор байгуулагдсан “Цэнхэр сүлд” нийгэмлэг үйл ажиллагаагаа төр, олон нийт, иргэний нийгмийн байгууллага, эрдэм шинжилгээ судалгааны институцүүд, олон улсын байгууллагуудтай хамтран Монголын статусыг үндэсний, олон улсын болон бүс нутгийн түвшинд урагшлуулах зорилгоор өргөн цар хүрээтэй үйл ажиллагаа явуулж байна.